



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/33

Бүрд сум

Хоршоо хөгжүүлэх сангийн
зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03- дугаар сарын 4-ны өдрийн 153 дугаар тогтоол, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.2, 3.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох зорилгоор хоршоонд хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгосугай.

2.Зээл олгох хоршооны нэр болон мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

3.Хоршоотой зээлийн гэрээ байгуулж, зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын байрны мэдээ тайланг аймгийн ХХААЖДҮГазарт хүргүүлж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Солонго)-д даалгасугай.

4.Дээрх зээлийг хоршооны нэрийн дансанд шилжүүлж, хоршоо хөгжүүлэх сангийн орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, улирлын эхний сарын 05-ны дотор Хүнс жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Г.Анхтөр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.ОЮУНДУЛАМ

622401072

Сумын засаг даргын 2025 оны.
дугаар сарын 11 өдрийн 13 дугаар
захирамжийн хавсралт

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН
ХОРШООНЫ НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Зээлд хамрагдсан хоршооны нэр	Зээлийн хэмжээ	Төслийн нэр/зориулалт	Санхүүжилт олгох хугацаа	Тайлбар
1	Буян Арвижих Цамид	40.000.000	Зоорь хүлэмж барих, хүнсний ногоо тариалах	5 сар	
	Дүн	40.000.000			

оОо